



УТЗ-н 2023 оны 06 сарын 02 өдрийн  
ФИНК 23/10/02 тоот тогтоолын  
Хавсралт №2

## ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах үүднээс удирдах албан тушаалтны ажлын байр түр болон урт хугацаанд эзэнгүй болох орон тоо гэнэт өөрчлөгдсөнөөс үүдэн гарч болох эрсдэлийг удирдахын тулд эрх бүхий албан тушаалтан болон эрх бүхий албан тушаалтнаас бусад газар, хэлтсийн захирал, Салбарын захирал, Ахлах нягтлан бодогчийн залгамж халааг тодорхойлоход оршино.
- 1.2 Байгууллагын эрх бүхий албан тушаалтан гэдэгт доорх албан тушаалтнуудыг ойлгоно.
  - 1.2.1 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
  - 1.2.2 Гүйцэтгэх захирал;
  - 1.2.3 Үйл ажиллагаа эрхэлсэн захирал
  - 1.2.4 Зээлийн газрын захирал
  - 1.2.5 Ерөнхий нягтлан бодогч

### ХОЁР. ЗАЛГАМЖ ХАЛААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

- 2.1 ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо /цаашид “Хороо” гэх/ байгуулан ажиллана.
- 2.2 Хороо нь залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулж ТУЗ батална.
- 2.3 Хороо нь эрх бүхий албан тушаалтан томилох нэр дэвшигчийг тухайн албан тушаалд тохирох эсэхийг боловсрол, туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно.
- 2.4 Эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх нэр дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба хөгжүүлж, үнэлж, дүгнэх замаар бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.5 Эрх бүхий албан тушаалтнаас бусад газар, хэлтсийн захирал, Салбарын захирал, Ахлах нягтлан бодогчийн залгамжлах нэр дэвшигчийг Хүний нөөцийн менежер холбогдох Газрын захирал эсвэл Гүйцэтгэх захиралтай хамтран тодорхойлох, өөрчлөх, томилох ба судалгаа хийнэ.
- 2.6 Хүний нөөцийн менежер нь Гүйцэтгэх захирлын хамтаар ажилтнуудын сургалт, хөгжлийн төлөвлөгөө гаргах бөгөөд албан тушаал дэвшин ажиллах боломжтой, чадварлаг ажилтнуудыг тодорхойлж, ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 2.7 Бизнесийн хэрэгцээ шаардлагаар газар, нэгж, хэлтсүүдийн орон тоог Гүйцэтгэх захирал санал болгож ТУЗ-ийн шийдвэрээр батална.

### ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1 Хороо нь компанийн эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлага нь тухайн ажлын байрны шаардлагыг хангаж байгаа эсэх, ашиг сонирхолын зөрчил үүссэн эсэхэд хяналт тавьж дүгнэлт гаргаж ажиллана.
- 3.2 Хорооноос эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулна.
- 3.3 Хороо нь ТУЗ-ийн хараат бус гишүүдийн бие даасан хараат бус байдлыг тогтоох тэдгээрийг сургах, мэргэшүүлэх ажлыг хариуцна.

## ДӨРӨВ. ЗАЛГАМЖ ХАЛААГ БЭЛТГЭХ

### 4.1 Эрх бүхий албан тушаалтны залгамж халааны төлөвлөгөө

4.1.1 Хороо нь эрх бүхий албан тушаалтны залгамжлах нэр дэвшигчийг олж тодорхойлно.

4.1.2 Нэр дэвшүүлэх хороо нь эрх бүхий албан тушаалтан томилох нэр дэвшигчийг тухайн албан тушаалд тохирох эсэхийг боловсрол, туршлага, гаргасан амжилтыг нь нягтлан шалгасны үндсэн дээр тодорхойлно.

4.1.3 Эрх бүхий албан тушаалтан шинээр буюу улираан нэр дэвшигчийг томилох, өөрчлөх саналыг Хорооноос ТУЗ-д гаргана. ТУЗ нь Гүйцэтгэх захиралд санал оруулж болно.

4.1.4 Өндөр насны тэтгэвэрт гарах болон ирээдүйд бий болох сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо нь жил бүр судалгаа хийнэ.

4.2 Эрх бүхий албан тушаалтнаас бусад газар хэлтсийн захирал, Салбарын захирал Ахлах нягтлан бодогчийн залгамжлах нэр дэвшигчийг Хүний нөөцийн менежер холбогдох Газрын захирал эсвэл Гүйцэтгэх захиралтай хамтран тодорхойлох, өөрчлөх, томилох ба судалгаа хийнэ.

## ТАВ. ГЭНЭТИЙН ТОХИОЛДОЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ БУЮУ ТҮР ТОМИЛГОО

5.1 Эрх бүхий албан тушаалтан гэнэтийн шалтгааны улмаас орон тоо нь чөлөөлөгдсөн тохиолдолд Хороо яаралтай хуралдаж ТУЗ-д санал оруулж шийдвэрлүүлнэ.

5.2 Эрх бүхий албан тушаалтнаас бусад газар, хэлтсийн захирал, Салбарын захирал, Ахлах нягтлан бодогч нь гэнэтийн шалтгааны улмаас чөлөөлөгдөх тохиолдолд орлох ажилтанг Хүний нөөцийн менежер холбогдох Газрын захирал, Гүйцэтгэх захирал нарын бүрэлдэхүүнтэй яаралтай хуралдан компаний дүрэм журам, холбогдох хууль тогтоомжийн дагуу томилгоог албажуулна.

## ЗУРГАА. ХЯНАЛТ

6.1 Энэхүү бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлд ТУЗ-ийн дэргэдэх Нэр Дэвшүүлэх Хороо хяналт тавин ажиллана.

